

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ**

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

*/2020 оны 7 сарын байдлаар/*

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	<u>Сумдын эмнэлэг</u>	<u>Өрхийн эмнэлэг</u>	<u>Хувийн эмнэлэг</u>	<u>Цэргийн анги</u>	<u>Нийт дүн</u>
1	Нийт үзлэг	68210	74624	35296	22649	3593	205372
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	24416	31911	5889	1608	3319	67123
3	Идэвхтэй хяналтын үзлэг	6470	12223	13385	3009	1	35068
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	21639	13396	6853	5939	210	48037
5	Нийт төрөлт	796	166				962
6	Хэвтэн эмчлүүлэгчид	4442	3010		1853	25	9130
7	Нас баралт	27	78	77			182

№	Үзүүлэлт	<u>2019.7</u>	<u>2020.7</u>	<u>Өөрчлөлт</u>
1	Нийт үзлэг	209959	205372	-4587
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	71844	67123	-4721
3	Идэвхтэй хяналтын үзлэг	32005	35068	3063
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	45548	48037	2489
5	Нийт төрөлт	910	962	52
	Гэрийн төрөлт	3	4	-1
6	Хэвтэн эмчлүүлэгчид	9341	9130	-211
7	Нас баралт	203	182	21
	0-1 насны эндэгдэл	18	13	5
	1-5 насны эндэгдэл	3	2	1
	Хурц халдварт өвчин	105	113	-8

Үзүүлэлт	хэмжих нэгж	2019.7 он	2020.7 он	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	19.6	13.4	-6.1
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	478.1	399.1	-79
<b>Үүнээс охидын</b>	хувь	5.7	8	2.3
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	15.4	16.1	0.7
БЗДХ	10000 хүн амд	20.1	33.7	13.6
<b>Үүнээс өсвөр үе</b>	хувь	13.1	11.3	1.8
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	81	72	-9
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	47	35	-12

**I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 205372 хүнд үзлэг шинжилгээ хийсний 49.7%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 9130 хүнийг 59111 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 7364 дуудлагад явж үйлчилсний 1009 /13.7%/ нь алсын дуудлага, 392 /5.3%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 84.3% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна.
- Нийт эмийн сангууд 49525 жор хүлээн авч, 5.0 тэрбум төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 11986 жор ирсний 47.3% /5680/ нь ЭМДаатгалын, 1.8%/224/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 50.7% /6082/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 80.6% байна.

## II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 7 сарын байдлаар 48037 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2489 тохиолдлоор нэмэгдсэн байна.
- 7 сарын байдлаар 857 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 27 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 12-р буурч , өвчлөл 130 тохиолдлоор өссөн байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 18.5 %/5 /нь амиа хорлосон / **БО-1,Мн-1,ХБ-1, ЭХ-2/**, 3.7%/1/ нь бусад хорлогдож /Бу/, 40.7% /11/нь зам тээврийн осол-/Гт-2,Нн-1,ШБ-1,Эу-2,БОЭТ-5,/ 37% /10/ нь бусад ослоор /Бд-1, Бу-1, Гт-2, Хү-1,ШБ-5/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 66,6%/18/ эрэгтэй хүмүүс эндсэн ба 5 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч хоног болоогүй нас баралт 3 /40%/ байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 182 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14,8 % нь осол гэмтлээр, 19,2% нь хорт хавдраар, **20,5%** нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 3,8% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 13 /Гт-2,Мн-1,Но-1,Хү-1,Цц-1,БОЭТ-7/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 13,4% байна.
- Нялхсын эндэгдэл 2019 онд 72,2% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2020 онд 53,8% нь эрт нярайн, 30.7% нь сараас дээш насны хүүхэд байгаа ба хатгаа/1/, осол гэмтэл /2/, тархинд цус харвалт /1/ зэрэг шалтгаанаар эндсэн байна
- БОЭТөвд 27 эндэгдэл тохиолдож 22 задлан шинжилгээнд хамруулсан ба задлан шинжилгээний хувь 81.4% тай байна. Үндсэн оноошийн зөрөө 4.

## III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 962 эх төрж 967 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 52 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 68 /7%/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна. / **БО-1, Бу-3,Гт-8,Мн-7,Но-3,Сэ-2,ХБ-4,Хх-3,Хү-2,Цо-3, Цц-6,ШБ-8,Өо-8, Эх-8,Бг-2/**.
- 7 сарын байдлаар 386 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 399.1 байгаа нь өнгөрсөн оноос **79-р** буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт-31/8%/ **Бу-2,Гт-1,Мо-3,Мн-1,Нн-2,ХБ-1,Цо-2,Цц-2,ШБ-9,Өо-3,Эх-5/** байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 79-р буурсан боловч , охидын үр хөндөлт 2,3-р нэмэгдсэн байна.
- 7 сарын байдлаар сард дундажаар 3598 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 53,4 % эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байгаа ба 16 хүүхэд туранхай, 10 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 9-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 12-р тус тус буурсан ба хяналтын хувь нэмэгдэхэд тураалын тархалт нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

## IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 367 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 110 тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний 23,4%-г салхинцэцэг,4,6% сүрьеэ, 1,6%-г гар хөл амны өвчин,2,7% цусан суулга, 64,3%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 14% нь жирэмсний үзлэгээс, 25,5% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 42.6% нь өвчний учир амбулатороор, 8.2% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

**Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох**

